



Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа
БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

(2026 оны II сар)

ГАРЧИГ

БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2026 ОНЫ II САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН 3

1. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ 3

1.1. Ажиллах хүч илгээх санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой гүйцэтгэсэн ажил 3

1.1.1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар хөдөлмөрийн гэрээт ажилчдад хүргэсэн үйлчилгээ 3

1.1.2. Бусад төрлийн визтэй болон визгүй оршин сууж буй иргэдэд үзүүлсэн үйлчилгээ 5

1.1.3. Нийгмийн хамгаалал, хүүхэд, гэр бүлийг дэмжих чиглэлээр хүргэсэн үйлчилгээ 6

1.1.4. Ур чадвартай ажилчны (E-7-4) виз руу шилжихэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 6

1.2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (хүснэгтээр) 7

1.2.1. Өргөдөл, гомдлын дагуу олгуулсан мөнгөн дүн, үйлчилсэн иргэний тоо 7

1.2.2. Хүлээж авсан өргөдлийн шийдвэрлэлт 7

1.2.3. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэлт 7

2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ 9

2.1. Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, нийгмийн даатгалтай холбоотой гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ 9

2.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх ажил 9

2.3. Зөвлөгөө мэдээлэл, бусад үйлчилгээ 10

2.4. Нийгмийн даатгалын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр) 10

3. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ЯВУУЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ 12

3.1. Сургалт сурталчилгаа, явуулын болон сэтгэл зүйн үйлчилгээ 12

3.2. Зарим дотоод ажил 13

БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2026 ОНЫ II САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн үйл ажиллагаа нь Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, хоёр улсын холбогдох яамдын хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд хэрэгждэг.

Тус төв нь БНСУ-д ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээг, гэр бүл, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд шаардлагатай төрийн үйлчилгээг хүргэх чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага юм.

2026 оны II сард төвийн дүрэм, хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүрэг, эрхлэх асуудлынхаа хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, иргэдэд хүргэсэн төрийн үйлчилгээг (хөдөлмөр, нийгмийн хамгаалал болон нийгмийн даатгалын чиглэлээр ангилж) энэхүү тайланд дурьдав.

1. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

(Тайлант хугацаа 2026.01.06 - 2026.02.27)

1.1. Ажиллах хүч илгээх санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой гүйцэтгэсэн ажил

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь 2026 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаанд хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдвэрлүүлэхээр танхим, цахим, утас болон факсаар хандсан нийт **320** иргэний санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, ажил олгогч эзэд болон холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээ үзүүлэн, өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажиллав.

Тус ажлын үр дүнд БНСУ-ын Самсунг даатгалын оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал: 13,408,490 вон, нутаг буцах зардал: 3,075,720 вон, үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү 2,607,535 вон, олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс: 7,015,000 вон, эмнэлгийн үнэ төлбөргүй тусламж үйлчилгээ 1,075,000 вон зэрэг хэлбэрээр нийт **27,178,745** воныг Монгол Улсын **37** иргэнд олгуулав.

1.1.1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар хөдөлмөрийн гэрээт ажилчдад хүргэсэн үйлчилгээ

- Иргэн Ц.А (Е-7) нь визний ангиллаа сольсон тул холбогдох баримтыг бүрдүүлэн Самсунг даатгал руу илгээж, 13 дахь сарын цалин 6,386,990 вон, нутаг буцах зардал 524,190 воныг олгуулав.

- Иргэн Г.Д (Е-7) нь визний ангиллаа сольсон тул холбогдох баримтыг бүрдүүлэн Самсунг даатгал руу илгээж, нутаг буцах зардал 539,230 воныг олгуулав.
- Иргэн С.С-ийн (Е-9) 13 дахь сарын цалин 7,021,500 вон, нутаг буцах замын зардал 500,000 вон, нийт 7,521,000 воныг Самсунг даатгалаас нэхэмжлэн олгуулсан.
- Иргэн Т.А-гийн (Е-9) үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү мөнгө 2,607,535 воныг нэхэмжлэн олгуулав.
- Иргэн Г.У (Е-7) нь визний ангиллаа сольсон тул Самсунг даатгалаас нутаг буцах зардал 512,300 воныг нэхэмжлэн олгуулав.
- Иргэн Ц.М-ийн (Е-9) нутаг буцах замын зардал нийт 500,000 воныг Самсунг даатгалаас нэхэмжлэн олгуулсан.
- Иргэн Ц.Т-гийн (Е-9) нутаг буцах замын зардал нийт 500,000 воныг Самсунг даатгалаас нэхэмжлэн олгуулсан.
- Иргэн О.Б (Е-9) нь нутаг буцсан тул 13 дахь сарын цалин болон нутаг буцах зардлыг нэхэмжилж Самсунг даатгал руу хүсэлтийг илгээсэн.
- Иргэн Э.П-гийн (Е-9) Самсунг даатгалын газарт байршуулсан нутаг буцах зардал, 13 дахь сарын цалин олгох хүсэлтийг 2026.01.27-ны өдөр хүлээн авч материал бүрдүүлэн илгээсэн.
- Иргэн Э.Б (Е-9), Ц.М (Е-9) нарын олгогдоогүй цалин хөлсний маргаантай холбоотой шийдвэрийг Хөдөлмөрийн хэлтсээс Хөдөлмөр халамжийн хэрэг эрхлэх газарт (대한법률구조공단 근로복지공단) хүргүүлэхэд дэмжлэг үзүүлэв.
- Иргэн Ц.Б (Е-9), Б.А (Е-9) нар нь 2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр БНСУ-ын Жэжү хотод хөдөө аж ахуйн салбарт хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирсэн боловч ажил олгогч нь Ичон хотод хөдөлмөрийн гэрээнд зааснаас өөр газарт ажиллуулж байгаад 01 дүгээр сарын 20-ны өдөр ажлаас халсан. Сөүлийн Хөдөлмөрийн хэлтэст ажлын байр солих мэдэгдэл хийлгэхээр хандахад бүс нутгийнхаа харьяа хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлэх шаардлагатай гэсэн. БНСУ-ын Хөдөө аж ахуйн нэгдсэн холбоо болон Өмнөд Чолла мужийн Хөдөлмөрийн хэлтэстэй холбогдож, орчуулга хийн ажил хайгчаар бүртгүүлснээр иргэн Б.А нь морины зүчээнд ажилд орсон. Иргэн Ц.Б нь байрлах газаргүй тул ажлын байр олтол тус мужийн хамгаалах байранд байрлуулсан.
- Иргэн Б.О нь (Е-9) ажил олгогчдоо алхны ишээр толгой руугаа цохиулсан асуудлаар 2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр тус төвд хандсан ба эмнэлэгт үзүүлэхэд нь орчуулгын дэмжлэг үзүүлсэн. 2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр тус Хөдөлмөрийн тасгийн мэргэжилтэн нь Монгол Улсаас БНСУ-д суугаа ЭСЯ-ны Хөдөлмөрийн асуудал хариуцсан ажилтантай хамт Тэсонкиге (대성기계) үйлдвэрт очиж ажил олгогчтой нь уулзан, ажилтныг Янжү эс эмнэлэгт (양주예쓰병원) үзүүлж гэмтлийн зэргийг тогтоолгон, Чорвоны цагдаагийн хэлтэст (철원군경찰서) ажилтны биед гэмтэл учруулсан асуудлаар өргөдөл гаргасан. Тухайн ажилтан нь байрлах газаргүй тул Бүчон хотын гадаадын иргэдийг дэмжих төвийн (부천시주민센터) дотуур байранд

байрлуулж, 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр цагдаагийн хэлтэст мэдүүлэг өгөхөд орчуулга хийв. Түүнчлэн ажлын байр хайхад нь дэмжлэг үзүүлж 강원도 영월고용센터, 경상북도 구미고용센터-тэй холбогдон, 경상북도 구미시 хотын 미광축산 үйлдвэрээс ажлын санал авснаар 2026.01.30-ны өдөр иргэн Б.О гэрээ байгуулан ажилд орсон.

- Иргэн Ц.Урамбаяр нь стандарт хангаагүй байранд байрлуулж байгаа талаар ажил олгогчдоо гомдол саналаа гаргахад ажил олгогч нь Монгол руу буцаана гэсэн тул тус төвд 2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр өргөдөл гаргасан. Нөхцөл байдлыг судлан ажилчдын байрны стандарт хангаагүй асуудлаар Гуанжү бүсийн Хөдөлмөрийн хэлтэст (광주지방노동지청) өргөдөл гаргасан. Хөдөлмөрийн хэлтсээс ажил олгогчид сануулга өгч, ажилтныг ажлын байр солих боломжтой гэсэн шийдвэр гарсан.

1.1.2. Бусад төрлийн визтэй болон визгүй оршин сууж буй иргэдэд үзүүлсэн үйлчилгээ

- Иргэн Ш.О-гийн (визгүй) барилгын мужааны ажил хийгээд авч чадаагүй хойшлогдсон цалин болох 4,415,000 воныг ажил олгогчоос нэхэмжлэн олгуулсан.
- Иргэн П.О-гийн (визгүй) барилгын ажил хийгээд авч чадаагүй цалингийн үлдэгдэл 2,680,000 воныг ажил олгогчоос нэхэмжлэн, олгуулахаар ажиллаж байна.
- Иргэн Л.О (визгүй) ажилласан хугацааны авч чадаагүй цалин 2,000,000 воныг олгуулан ажилласан.
- Иргэн Ч.Ю-гийн (визгүй) 2025.12.18-20-ны өдрүүдэд барилгын нураалт хийсэн ажлын хөлс 720,000 воныг ажил олгогчоос нэхэмжилсэн ч тохиролцсон хугацаандаа барагдуулаагүй тул Хөдөлмөрийн хэлтэст (의정부지청) 2025.01.21-ний өдөр өргөдөл гаргасан.
- Иргэн Ц.Б (визгүй) нь барилгын ажил хийсэн цалингийн үлдэгдлээ авч чадалгүй нутаг буцсан ба олгогдоогүй цалинг ажил олгогчоос нэхэмжилж 700,000 воныг олгуулсан.
- Иргэн С.Г-гийн (G-1) 2025 оны 11 сарын 29-нөөс 2025 оны 12 сарын 22-ны өдрийг хүртэлх ажилласан хугацааны олгогдоогүй цалингийн үлдэгдэл 600,000 воныг 2026 оны 01 сарын 17-ны өдөр олгуулав.
- Иргэн С.О-гийн олгогдоогүй цалин 900,000 воныг нэхэмжилж, Хөдөлмөрийн хэлтэст (서울고용노동청) өргөдөл гаргасан.
- Иргэн Б.Ж-гийн (визгүй) 13 дахь сарын цалингийн хүсэлтийг Самсунг даатгал руу илгээсэн.
- Иргэн Ш.Б-гийн олгогдоогүй цалин хөлсний өргөдлийг 2026.01.26-ны өдөр хүлээн авч материал бүрдүүлэлтийг хүлээж байна.
- Иргэн С.С (визгүй), А.Н (визгүй), С.Б (визгүй), Д.Б (визгүй), С.Б (визгүй), Э.М (визгүй), Б.Г (визгүй), Б.Ж (визгүй), С.Э (визгүй) нарын сайн дураар нутаг буцах мэдэгдлийг Цагаачлалын албанд мэдүүлсэн.
- Иргэн Ч.З (G-1), Б.Б (G-1) нарын хэлний бэрхшээлтэй иргэдийн ажилласан хугацааны олгогдоогүй цалингийн маргаан шийдвэрлэх хурал 2026 оны 01

дүгээр сарын 20-ны өдөр Гуанжу хотын хөдөлмөрийн хэлтэст (광주지방고용노동청) болсон ба тус төвийн Хөдөлмөрийн тасгийн мэргэжилтэн нь Пусаны дэд консулын хамт оролцож дэмжлэг үзүүлэн ажиллав.

- Иргэн Т.Б (С-3), Л.М (С-3) нар нь хоолны газар ажилласан сарын цалингаа авч чадаагүй нутаг буцсан. Өргөдөл гаргагчдаас шаардлагатай баримт бичгийг бүрдүүлж, итгэмжлэл гаргуулан, Инчон хотын Хөдөлмөрийн хэлтэст (인천북부지청방고용노동청) өргөдөл гаргав.

1.1.3. Нийгмийн хамгаалал, хүүхэд, гэр бүлийг дэмжих чиглэлээр хүргэсэн үйлчилгээ

“Эрүүл мэндийн үйл ажиллагаа явуулж буй эмч нарын нэгдсэн холбоо” ТББ болон Сөүл хотын "Seoul Jump Medical Center"-тэй хамтран 2026 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр эрүүл мэндийн анхан шатны үнэ төлбөргүй үзлэг оношилгоог зохион байгуулж, визгүй 13 иргэнийг хамруулан, орчуулгын туслалцаа үзүүлэв.

ХХҮЕГ-ийн Нийгмийн Халамжийн Бодлогын Хэрэгжилтийн газрын дарга Т.Бадрахбаяр, НДЕГ-н дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн дарга Т.Лхагвадорж, ХНХҮТ-ийн дарга Б. Жаргалмаа, болон төвийн нийгмийн халамж, гэр бүл хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд 2024 оны 01-р сарын 14-ний өдөр цахим хуралд оролцов. Тус хурлаар Солонгос улсад амьдарч буй иргэдийн нийгмийн халамжийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй хүргэх чиглэлд хамтран ажиллах боломжийн талаар зөвлөлдөж, мэдээлэл солилцсон.

1.1.4. Ур чадвартай ажилчны (E-7-4) виз руу шилжихэд дэмжлэг үзүүлэх үйлчилгээ

- Хөдөлмөрийн гэрээт ажилчны E-9 визээс ур чадвартай ажиллах хүчний E-7-4 виз руу шилжсэн иргэдийн судалгаанд тайлант хугацаанд 5 иргэнийг, E-7-4 виз руу шилжих хүсэлтэй болон хугацааны болзол хангасан иргэдийн судалгаанд 8 иргэнийг шинээр бүртгэсэн.
- E-7-4 визний асуудлаар нийт 46 иргэнтэй утсаар болон цахимаар холбогдож бүрдүүлэх баримт бичиг, оноо тоолох, гэр бүлээ урих, ТОПИК шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалтад бүртгүүлэх, жолооны үнэмлэх авах, ажлын байр солих, D-10, F-2, E-7-4R, F-2R ангилал руу өөрчлөх зэрэг асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгсөн.
- E-7-4 визний асуудлаар “E-7-4 визний мэдээлэл солилцох групп” сошиал групп үүсгэн визээ сольсон, солих хүсэлтэй иргэдийг нэгтгэж байгаа ба гишүүдийн тоо 856 байна. Мэдээлэл сурталчилгааг идэвхжүүлэх зорилгоор тус сошиал хуудсанд Нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн шалгалтын жишиг тестүүд, Монгол хүнд зориулсан бие даан солонгос хэл сурах гарын авлага, БНСУ-ын хууль дүрмийн өөрчлөлт зэрэг 24 удаагийн мэдээлэл зөвлөгөөг нийтэлсэн.

1.2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (хүснэгтээр)

1.2.1. Өргөдөл, гомдлын дагуу олгуулсан мөнгөн дүн, үйлчилсэн иргэний тоо

| Тоон мэдээллийн агуулга | Гүйцэтгэлийн тоон үзүүлэлт | |
|--|----------------------------|---------------------|
| | Иргэн | Олгуулсан дүн (вон) |
| 1) Нутаг буцах зардал | 6 | 3,075,720 |
| 2) Цалин, илүү цагийн хөлс | | |
| 3) Самсунгийн 13 дахь сарын цалин | 2 | 13,408,490 |
| Хөдөлмөрийн гэрээт ажилчдад 4) Үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү мөнгө | 1 | 2,607,535 |
| 5) Үйлдвэрлэлийн ослын даатгал | | |
| 6) Гэнэтийн ослын даатгал | | |
| 7) Гэнэт халагдсаны тэтгэмж | | |
| 8) Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад | 2 | |
| 9) Олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс | 3 | 2,600,000 |
| Бусад төрлийн визээр оршин суудаг иргэдэд 10) 13 дахь сарын цалин | | |
| 11) Үйлдвэрлэлийн ослын даатгал | | |
| 12) Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад | | |
| Хууль бусаар оршин суудаг иргэдэд 13) Олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс | 1 | 4,415,000 |
| 14) 13 дахь сарын цалин | | |
| 15) Үйлдвэрлэлийн ослын даатгал | | |
| 16) Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад | 22 | 1,015,000 |
| Монгол Улсын иргэдэд олгуулсан дүн | 37 | 27,121,745 |

1.2.2. Хүлээж авсан өргөдлийн шийдвэрлэлт

| Нийт өргөдөл | Шинээр хүлээн авсан өргөдөл | Шийдвэрлэлтийн байдал | | | |
|--------------|-----------------------------|---------------------------|-------------------------------|------------------|----------------|
| | | Хугацаанд нь шийдвэрлэсэн | Бусад байгууллагад шилжүүлсэн | Хугацаа хэтэрсэн | Шийдвэрлэж буй |
| 71 | 35 | 19 | 26 | - | 26 |

1.2.3. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэлт

| Үйлчилгээ | Тоо |
|---|-----|
| 1) Самсунг даатгалын газраас 13 дахь сарын цалин болон нутаг буцах замын зардал авах материалыг бүрдүүлэн, даатгалыг олгуулах, нутаг буцахтай холбоотой зөвлөгөө, мэдээлэл өгөх | 13 |
| 2) Үйлдвэрээс авах 13 сарын цалингийн зөрүү бодолт хийх аргачлалыг танилцуулах, бодолт хийх, ажил олгогчоос нэхэмжлэн олгуулах | 8 |

| | |
|---|--------------|
| 3) Гэрээт ажилчдын ажлаас гарах өргөдөл гомдлын дагуу судлан, асуудлыг шийдвэрлүүлэх | 12 |
| 4) Олгогдоогүй цалин хөлсний маргааныг шийдвэрлэж, цалин, хөлсийг олгуулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх | 24 |
| 5) Цалин, илүү цаг, амралтын хөлсийг бодох болон тооцоолох аргачлалын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх | 2 |
| 6) Үйлдвэрлэлийн ослын тухай, осолд орсон иргэнийг ослын даатгалд хамруулж, ажилгүйдлийн тэтгэмж болон нөхөн олговрыг олгуулах | 1 |
| 7) Гэнэтийн ослын талаар мэдээлэл зөвлөгөө өгч, даатгалд хамруулж, нөхөн олговрыг олгуулах | 3 |
| 8) Үндэслэлгүй болон ажил олгогчийн буруутай үйлдлээс шалтгаалан ажлын байр сольсон, гэнэт халагдсан тохиолдолд материалыг бүрдүүлэн, гэнэт халагдсаны тэтгэмж, бусад тэтгэмжийг олгуулж, өргөдлийг шийдвэрлүүлэх | 7 |
| 9) Хөдөлмөрийн гэрээ сунгах (1жил 10сар), тусгай болон тогтвортой нөхцөлөөр дахин ирэх, давтан гэрээ байгуулахтай холбоотой бүх төрлийн мэдээлэл, зөвлөгөө өгөх | 2 |
| 10) Бүх төрлийн аман болон бичгийн орчуулгын үйлчилгээ. Үүнд: БНСУ-ын Засгийн газрын байгууллага: - Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам - Хөдөлмөрийн хэлтэс - Төв бирж - Эрүүл мэндийн газар - Хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний төв - Үндэсний тэтгэврийн алба - Хөдөлмөр, халамжийн газар Хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагатай холбоотой аман болон бичгийн орчуулга | 26 |
| 11) Хөдөлмөрийн гэрээт иргэдийн хамрагдах даатгал (ЭМД, ГОД, ҮОД, НД)-ын асуудлаар нарийвчилсан мэдээлэл, зөвлөгөө өгөх | 6 |
| 12) Жилийн эцсийн тайлангаар ХАОАТ-ын буцаалт хэрхэн авах тухай мэдээлэл хүргэх, зөвлөгөө өгөх | 1 |
| 13) Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх газар (ХЭХЯ), Шүүхийн шатанд өргөдөл, гомдол гаргах асуудлыг шийдвэрлэх, Хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний төв, Хөдөлмөр халамжийн корпорац, Сөүлийн баталгаат цалингийн даатгалын газарт иргэний өргөдлийг дамжуулан өгч шийдвэрлүүлэх | |
| 14) Монгол иргэдийн сайн дураар нутаг буцах мэдэгдэл гаргах, оршин суух хугацааг шалгах, сунгах хүсэлт гаргах, цаг авахад туслах | 2 |
| 15) Визний ангилал солиулахад (Е9-өөс Е-7-4 виз рүү) оноо цуглуулах, топик шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалтад бүртгүүлэхэд мэдээлэл, зөвлөгөөгөөр тусалж, дэмжих | 47 |
| 16) Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх | 22 |
| 17) Бусад мэдээлэл, зөвлөгөө | 91 |
| 18) ХурДан төрийн цахим үйлчилгээг хүргэх | 52 |
| | Утсаар 165 |
| | Цахимаар 85 |
| | Танхимаар 70 |
| Нийт | 320 |
| Хүргэсэн үйлчилгээний тоо | |

2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

(Тайлан хамарсан хугацаа 2026.02.01 - 2026.02.28)

2.1. Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, нийгмийн даатгалтай холбоотой гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа болон бусад хэлбэрээр ажиллаж, амьдарч байгаа иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар хамруулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх үйл ажиллагаа:

- 1) Хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажиллаж буй иргэдээс 8 иргэнийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулж, холбогдох программд бүртгэн, гэрээ байгуулсан.

❖ Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ:

- 24 иргэний гэрчилгээний хугацааг сунгасан;
- 8 иргэнд дахин гэрчилгээ олгосон;
- 8 иргэнд шинээр гэрчилгээ олгосон.

Нийт 40 иргэнд чөлөөлөгдөх гэрчилгээ олгож, үйлчилгээ үзүүлсэн.

- 2) БНСУ-д бусад төрлийн визтэй оршин суугч Монгол иргэдээс 34 иргэнийг сайн дурын даатгалд хамруулж, холбогдох программд бүртгэн, гэрээ байгуулсан.

❖ Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ:

- 21 иргэний гэрчилгээний хугацааг сунгасан;
- 3 иргэнд дахин гэрчилгээ олгосон;
- 9 иргэнд шинээр гэрчилгээ олгосон.

Нийт 33 иргэнд чөлөөлөгдөх гэрчилгээ олгож, үйлчилгээ үзүүлсэн.

2.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх ажил

Тайлант хугацаанд тус тасаг 255,405,387.00 төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн бөгөөд орлогын сарын төлөвлөгөө 58 хувийн гүйцэтгэлтэй байна.

Шимтгэлийн 111,977,180 төгрөгийн орлогыг БНСУ-ын 3 банкны сангийн харилцах данснаас Нийгмийн даатгалын ерөнхий газрын Төрийн банкин дахь төвлөрүүлэх дансанд бүрэн шилжүүлж, сарын мэдээг хуульд заасан хугацаанд гаргасан. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Шилэн дансны тухай хуульд тус тус заасны дагуу тайлан, мэдээллийг Сангийн яамны холбогдох мэдээллийн санд байршуулсан.

2026 оны 02 дугаар сард нийт 47 даатгуулагчийн 3 болон түүнээс дээш сарын 39,967,948.00 төгрөгийн шимтгэлийн авлагыг барагдуулсан. Үүнд, албан журмын даатгалын 34 даатгуулагчийн 35,481,408.00 төгрөг, сайн дурын даатгалын 13 даатгуулагчийн 4,495,540.00 төгрөг байна.

2.3. Зөвлөгөө мэдээлэл, бусад үйлчилгээ

БНСУ-д амьдарч буй иргэд болон хөдөлмөрийн гэрээт иргэдийг зөвлөгөө мэдээллээр дэмжих, өргөдөл гомдлыг шийдвэрлүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, гадаад хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 1) Тайлант хугацаанд Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах, орчуулга хийх зэрэг зөвлөгөө мэдээллийг утас, цахим, танхимаар нийт 406 иргэн, даатгуулагчид үйлчилгээг үзүүлсэн.
- 2) БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хугацаандаа БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд даатгуулаад нутаг буцсан, төлсөн шимтгэлээ буцааж авахаар ирүүлсэн 1 ээлжийн 2 иргэний 4,455,000.00 вон нэхэмжилсэн хүсэлтийг холбогдох бичиг баримтын хамт тус улсын Үндэсний тэтгэврийн албанд хүргүүлсэн.
- 3) БНСУ-д оршин сууж байгаа Монгол Улсын иргэдийн амьдарч оршин суух нөхцөл, ажил эрхлэлт, нас хүйс болон нийгмийн даатгалд даатгуулсан байдал, нийгмийн даатгалын талаарх ойлголт хэр зэрэг байгааг танин мэдэх зорилгоор 64 иргэнээс судалгаа авсан.

2.4. Нийгмийн даатгалын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр)

| Үйлчилгээ | | Тоо | Өссөн дүнгээр |
|--|-------------------------------|------------------------------|------------------------------|
| 1. Даатгалд шинээр хамруулсан | Албан журмын даатгал | 8 | 130 |
| | Сайн дурын даатгал | 34 | 132 |
| 2. Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ олгосон (Албан журмын даатгал) | Шинээр | 8 | 96 |
| | Дахин | 8 | 10 |
| | Хугацаа сунгасан | 24 | 50 |
| 3. Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ олгосон (Сайн дурын даатгал) | Шинээр | 9 | 62 |
| | Дахин | 3 | 8 |
| | Хугацаа сунгасан | 21 | 62 |
| 4. Шимтгэлийн орлого төвлөрүүлэлт | Албан журмын даатгал | 111,376,800.00 62% | 208,102,000.00 55% |
| | Сайн дурын даатгал | 144,028,587.00 55% | 332,825,673.00 64% |
| | Нийт | 255,405,387.00 58% | 540,927,673.00 60% |
| 5. Гурав болон түүнээс дээш сарын шимтгэлийн авлага барагдуулалт | Албан журмын даатгал | 35,481,408.00 | 71,864,508.00 |
| | Сайн дур | 4,495,540.00 | 19,739,930.00 |
| 6. БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын буцаан олголт | Нэхэмжилсэн | 4,455,000.00 | 23,883,780.00 |
| | Олгосон | 0 | 0 |
| | Буцаан олголт авсан хүний тоо | 0 | 0 |

| | | | |
|--|-----------|-----|-----|
| 7. Иргэдэд өгсөн зөвлөгөө, мэдээлэл | Утсаар | 357 | 801 |
| | Цахимаар | 12 | 82 |
| | Танхимаар | 37 | 98 |

3. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ЯВУУЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

3.1. Сургалт сурталчилгаа, явуулын болон сэтгэл зүйн үйлчилгээ

Төвийн БНСУ дахь “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” сошиал хуудсанд 23, youtube сувагт 5, байгууллагын <https://seoulcenter.mlsp.gov.mn> цахим хуудсанд 23 мэдээлэл, зөвлөгөө нийтэлж сурталчилснаар иргэдээс нийтдээ 253,408 удаа хандсан байна.

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирэх 50 иргэнд ирэхээс өмнөх сургалтыг 2026.01.09 болон 30-ны өдрүүдэд цахимаар, ирсний дараах сургалтыг 2026.01.14-ний өдөр 8 иргэн, 2026.02.05-ны өдөр 41 иргэнийг хамруулан Ичон, Ёжүгийн сургалтын төвүүдэд танхимаар тус тус зохион байгуулж дараах агуулгын хүрээнд мэдээлэл өгөв. Үүнд:

- ХНХҮТ-ийн үйл ажиллагааны танилцуулга
- Цалин хөлс тооцох, ажлын байр солих талаар
- Үйлдвэрлэлийн ослын даатгал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ослоос урьдчилан сэргийлэх тухай
- Солонгос улсын хууль, журам, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар
- Суугаа орондоо дасан зохицоход анхаарах зүйл
- Сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл
- Ур чадвартай ажиллах хүчний E-7-4 визний талаар
- Солонгос хэлний сургалт, урьдчилсан үнэлгээ хийх шалгалтуудын хуваарь
- Хууль бусаар оршин суухын сөрөг тал, хуулийн дагуу оршин суухын давуу тал зэрэг болно.

Жонжү хотод 2026.01.31-ны Бямба гарагт зохион байгуулсан явуулын үйлчилгээний үеэр тус төвөөс хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар 6 иргэнд, нийгмийн даатгалын асуудлаар 5 иргэнд зөвлөгөө өгч, нийт 54 иргэнд гарын авлага, тараах материал хүргэсэн.

Ичон хот орчимд ажиллаж амьдарч буй Монгол Улсын иргэдэд мэдээлэл хүргэх зорилгоор 2026.02.01-ний ням гарагт Жүан сүмийн цугларалтад оролцож, нийгмийн даатгалын асуудлаар 8 иргэнд, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар 20 гаруй иргэнд гарын авлага хүргэж ажиллав.

Тэжон хотод ажиллаж амьдарч буй Монгол иргэдийн Сар шинийн баярын арга хэмжээ 2026.02.15-ны өдөр зохион байгуулагдсан ба тус төвөөс явуулын үйлчилгээ үзүүлж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар 9 иргэнд, нийгмийн даатгалын асуудлаар 19 иргэнд биечлэн зөвлөгөө мэдээлэл өгсөн. Нийт 84 иргэнд гарын авлага, тараах материал түгээсэн.

2026.02.28-ны өдөр Гуанжү хотын Монгол-Солонгосын соёлын төвд 10 иргэнд нийгмийн даатгалын тухай мэдээлэл зөвлөгөө өгч, үйлчилгээ үзүүлсэн. Тодруулбал, нийгмийн даатгалын аппликейшныг 1 иргэний гар утсанд суулгаж, 1 иргэнийг нийгмийн даатгалд хамруулж, тэтгэврийн нас хүрэх болон хүрсэн 4 иргэнийг ажилласан жил, шимтгэл төлөлтийг шалгаж бусад холбогдох зөвлөгөө өгч, 1 иргэнд гэрчилгээ олгохоор болсон. Мөн БНСУ-д оршин сууж буй 12 иргэнээс товч судалгаа

авч, нийт 20 иргэнд нийгмийн даатгалын талаарх тараах материал өгч мэдээллээр хангаж ажиллав.

Тайлант хугацаанд 41 иргэнд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө өгсөн. Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тулгамдсан асуудлаар нь ангилж үзвэл сэтгэл гутралын асуудалтай 2, сэтгэл түгшилттэй 5, гэр бүлийн асуудалтай 1, бусад шалтгаантай 5 иргэн байна.

2026 оны 1 дүгээр сард хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар шинээр ирсэн 5 иргэнд нойргүйдэл илрүүлэх сорил, сэтгэл гутралын болон сэтгэл түгшилтийн сорил авч, дүгнэлт гаргав. Үүнд:

- Нойргүйдэл илэрсэн 2 иргэн (20-29 нас)
- Сэтгэл түгшилтийн завсрын байдалтай 1 иргэн (20-29 нас) байна.

Архаг ядаргаа стрессийг эергээр даван туулах, сэтгэл гутрал, сэтгэл түгшилт сэдвүүдээр тараах материалын эхийг бэлтгэж, “Awesome” сэтгүүлийн сэтгэл зүйчийн буланд оруулах зөвлөгөөг боловсруулан илгээв.

“Сэтгэлээ нээж ярилцъя” бүлгийн сэтгэлзүйн зөвлөгөө уулзалтыг 2026.01.20-ны өдөр тусгай хэрэгцээт 6 хүүхдийн эцэг, эхийг хамруулан зохион байгуулж, цаашид үе шаттайгаар уулзалтыг зохион байгуулахаар тохиров.

Солонгост ажиллаж, амьдарч буй иргэдэд зориулсан сэтгэл зүйн цахим сургалтыг “Стрессээ архиар тайлдаг уу” сэдвээр клиникийн профессор зөвлөх зэргийн эмч К.Еленатай хамтран 2026.02.01-ний Ням гарагт зохион байгуулж, 28 иргэнд сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав.

“Сэтгэл түгшилтийг таних удирдах арга зүй” сэдвээр сэтгэцийн эмч, сэтгэл засалч эмч Ц.Мөнхтуултай хамтран 2026.02.22-ний Ням гарагт сэтгэл зүйн цахим сургалтыг зохион байгуулж, 28 иргэнийг хамруулан сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн.

3.2. Зарим дотоод ажил

- Шинээр ирсэн гэрээт ажилчдын судалгаа, ур чадвартай ажилчдын судалгаа, нутаг буцаж буй иргэдийн судалгааны мэдээллийн санг шинэчлэв.
- Улирлын чанартай хөдөлмөр эрхлэлтийн E-8 (Seasonal Work) визээр ажиллаж буй иргэдийн асуудлаар танилцуулга, санал боловсруулан Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт 2026.01.22-ны өдрийн 1/17 дугаартай албан бичгээр хүргүүлэв.
- 2026.01.27-ны өдөр БНСУ-ын Үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн холбооны Бодлого төлөвлөлтийн 2 дугаар газрын дарга У Сэ Иль-д, 2026.01.28-ны өдөр Аж үйлдвэр, хүний нөөцийн хэрэг эрхлэх газрын Гадаад ажиллах хүчний бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Жан Со Ён-д уулзалт зохион байгуулах хүсэлт хүргүүлсэн.
- Эрүүл мэндийн даатгалын хувь хэмжээ, нийгмийн даатгалын хувь хэмжээний өөрчлөлт, Хөдөлмөрийн гэрээт иргэдийн ажлын байр солих болон Ажилчдын дотуур байрны стандартын эрх зүйн үндэслэлийг тасгийн дотоод албан хэрэгцээнд зориулж орчуулаад байна.

- - - оОо - - -